

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

*2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр, Мягмар гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-15</i>
<hr/>	
<i>1. Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	<i>4-9</i>
<i>2. “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	<i>9-15</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Эдийн засгийн байнгын хорооны 03 дугаар сарын 21-ний өдөр  
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52,6 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 54 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут, Ж.Бат-Эрдэнэ;

Чөлөөтэй: Х.Булгантуяа, Ж.Ганбаатар, Б.Жавхлан, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аюурсайхан, Д.Бат-Эрдэнэ, Ц.Даваасүрэн.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Тогтоолын төслийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэгийн тавьсан асуултад Байнгын хорооны дарга Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр, Н.Ганибал нар үг хэлэв.

**Ц.Цэрэнпунцаг:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 3

Бүгд: 10

70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 15 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр. “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Баасандорж, мөн газрын Салбарын удирдлага, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн, мөн газрын Засгийн газрын референт Д.Нямдэлгэр, Засгийн газрын Хяналт

хэрэгжүүлэх газрын Хяналт шалгалтын багийн ахлагч Д.Ган-Эрдэнэ, мөн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын Менежментийн багийн Ахлах нягтлан бодогч Н.Найданболд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Г.Баярмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулав.

Илтгэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, Б.Баттөмөр, С.Чинзориг нарын тавьсан асуултад Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, мөн газрын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл нар хариулж, тайлбар хийв.

**Ц.Цэрэнпунцаг:** “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 5  
Бүгд: 10  
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрмын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Ц.Цэрэнпунцаг:** Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрмын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 48 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52,6 хувийн ирцтэйгээр 15 цаг 42 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Ц.ЦЭРЭНПУНЦАГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ  
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим 14 цаг 54 минут

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Ц.Цэрэнпунцаг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Ингээд ирцээ танилцуулъя. Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн өвчтэй байна. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн орон нутагт ажиллаж байна. Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн өвчтэй байна. Ингээд бусад гишүүд хуралдаанд хүрэлцэн ирсэн байна.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж Байнгын хорооны ирц 52.6 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Хэлэлцэх асуудлын нэгт. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 03 дугаар сард Байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл.

Хоёрт.Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл/ Засгийн газар 2023.01.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ гэсэн 2 асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна.

**Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 03 дугаар сард Эдийн засгийн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.14 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос тогтоох нь.

Нэг.Монгол Улсын Их Хурлын даргын 2023 оны 03 дугаар сарын 14-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын 2023 оны ээлжит чуулганы 03 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай 49 дүгээр захирамжид заасан Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэх цаглаварыг хавсралтаар баталсугай.

Хоёр.Хуульд хэлэлцэх хугацааг тусгайлан заасан асуудал болон Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Эдийн засгийн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхэд энэ цаглавар хамаарахгүй.

Гурав.Энэ тогтоолын биелэлтийг хангаж, хэлэлцүүлэх асуудлын бэлтгэл хангахыг Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-д үүрэг болгосугай.

Төсөлтэй холбогдуулан асуулт асууж, санал хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Оюунчимэг гишүүнээр тасалъя. Оюунчимэг гишүүн асуултаа асууя.

**М.Оюунчимэг:** Энэ цаглаварт тусгасан 03 дугаар сард хэлэлцэх асуудлын хувьд бол санал нэг байна. Ихэнх нь хаврын чуулганаар хэлэлцэхийг дэмжсэн төслүүд орж ирсэн байна. Миний асуух гэж байгаа нэг зүйл нь одоо яг иргэдийн зүгээс бүхий л судалгаагаар хамгийн өндөр хувьтай бараг 40, 50% нь Улсын Их Хурал шийдвэр гаргах түвшинд хууль тогтоогчид минь энэ үнэ ханшийн өсөлт, цаг үеийн эдийн засгийн нөхцөл байдал, гурил, гурилан бүтээгдэхүүн, нөөцийн мах гээд өмнөх жилүүдтэй харьцуулахад бараг 2, 3 дахин өсчихлөө. Тэгээд энэ дээр Засгийн газарт чиглэл өгч эсвэл хамтарч ажиллаач. Энэ асуудлуудыг яриач гэдэг хүсэлт маш их ирж байна. Сая гишүүд тойрогтоо ажиллахад тэр нь маш өндөр хувьтай гарч байна. Судалгаагаар бас ингэж байна.

Тэгэхээр 3 сард хэлэлцэх асуудлын жагсаалтад Эдийн засгийн байнгын хороо иргэдийнхээ бас дээрээс нь магадгүй аж ахуйн нэгжүүд маань ч бас энийг хүсэж байж мэднэ. Үнэхээр ийм байдалтай байгаад байгаа юм байна. Тэгэхээр энэ үнэ хани, инфляц, энийг тойрсон энэ асуудал дээр Эдийн засгийн байнгын хороо хэлэлцэх цаг нь болжээ. Тэгэхгүй бол бид нар дандаа том, том хууль дээр юм уу эсвэл зүгээр нэг төлөвлөсөн асуудлыг л хэлэлцээд байна. Энэ чинь Улсын Их Хурлын бүхэл бүтэн эдийн засгийн бодлого дээр чухал тодорхойлох Байнгын хороо учраас энэ асуудлыг 03 сард хэлэлцэх жагсаалтад оруулбал ямар вэ гэсэн нэг санал байна.

2 дахь зүйл нь Цэрэнпунцаг дарга аа, нэг ийм юм бид нарт ирээд байна л даа. 8 нэрийн барааны дэлгүүрүүд, хүнсний дэлгүүрүүд, жижиг ресторан эрхлэгчдийн зүгээс эрх ашгийг хамгаалах

ч гэдэг юм уу энэ тал дээр төр, засгийн бодлогын зохицуулалт хэрэгтэй болж байна. Жишээлбэл хотын төвийн бараг бүх дүүргүүдийн хүнсний дэлгүүрүүд Си Ю, Жи Эс 25 гэдэг 2 зүгээр л яг зогсоо зайгүй дайралтаар орж байтал нөгөө манай жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч, хүнсний дэлгүүр ажиллуулдаг хүмүүсийг үүдээ барихад хүргэж байна. Энд зохицуулалт байдаггүй юм уу. Шударга өрсөлдөөн үнэхээр энд байна уу, үгүй юү гэдэг дээр төрийн бодлогын зохицуулалт хэрэгтэй байна гэсэн хүсэлтүүд ирээд байна л даа. Тэгэхээр бид нар энэ дээр ШӨХТГ-ыг дуудаж ирээд үнэхээр тэнд шударга өрсөлдөөн байна уу. Хэт монопольлоод байна уу. Эсвэл нөгөө том 1, 2 компанийн нөлөө жижиг, дунд бизнес эрхлэгчдийн эрх ашгийг нь дэндүү зөрчилтэй, тэнд бодлого байхгүй байгаад байна уу гэдэг дээр бас анхаарах хэрэгтэй байна гэсэн хүсэлтүүд ирж байгаа юм. Тэгэхээр энийг бид нар бас анхаарах цаг болсон байна гэж хэлмээр байна. Тэгээд энэ дээр та бодолцож хариулт өгөөч.

**Ц.Цэрэнпунцаг:** Оюунчимэг гишүүний асуусан асуудал болгоод тавьж байгаа гол нэрийн бараа, бүтээгдэхүүнүүдийн үнэ өсөөд байна гэж. Энэ асуудал бол байна. Энэ дээр бол бид нар Байнгын хорооноосоо гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах тухай хуулийг санаачлаад Их Хурлаар батлуулсан. Тэгэхээр энэ хуулийнхаа хэрэгжилт ямар байгаа талаар та хувь гишүүний хувьд бол асуулга тавьж болно. Тэгэхээр энэ зүгээр хууль байгаа учраас бид нар энэ хуулийн хэрэгжилт дээрээ бол араас нь. Тэгэхээр энэ сарын асуудлууд дунд бол та энийг оруулаач, оруулах боломж байна уу гэж байгаа юм байна. Тэгэхээр яах вэ энэ хурлынхаа явцад 3 сарын энэ хэлэлцэх асуудлууд дунд та өөрөө хувь гишүүнийхээ хувьд асуулга тавихад асуудалтай байвал хуулийн хэрэгжилтийн талаар ямар байгаа талаар асуулга тавьчихаж болно шүү дээ. Заавал Байнгын хороогоороо оруулж



оруулж хэлэлцэх эсэх нь ямар шаардлагатай байдаг юм. Тэгэхээр та өөрөө бас бодоорой. Энэ дээр бид нар хуваарь баталсан. Яг энийгээ энэ хуваарьт оруулна гэдгээр санал хураалгаж болох юм. Байнгын хороо дээрээ мэдээлэл авахаар ямар та энэ дээр санал хураалгаж болно шүү. Энэ цаглавар дээрээ оруулъя гээд.

2 дахь асуудал. Энэ жижиг дэлгүүрүүд өрсөлдөөн хүнд байгаа асуудал байгаа учраас энэ чинь бас дахиад л Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах газраас бид нар мэдээлэл аваад энэ тал дээр ямар байгаа талаар нь бид нар мэдээлэл аваад энэ дээр Байнгын хороо дээр мэдээлэл сонсож болох юм байна. Тэгэхээр та энэ дээр бас нэг санал хураалгаад Байнгын хорооны 3 сарынхаа хуваарьд оруулах тал дээр санал хураагаад шийдсэн нь дээр байх. Оюунчимэг гишүүн нэмэлт асуулт. 1 минут.

**М.Оюунчимэг:** Дарга аа, дэгийн тухай хуулиар угаасаа би сонсох тухай л ярьж байгаа байхгүй юу. Тухайн салбарын Байнгын хороо дээр энийг сонсох үүрэгтэй. Хэрвээ гишүүн нь юм уу, Байнгын хороо санал гаргавал энэ чинь Эдийн засгийн байнгын хороо учраас Эдийн засгийн байнгын хороон дээр холбогдох албан тушаалтнуудаа авчраад бид нар мэдээлэл сонсьё. Тэгээд тэр мэдээлэл дээр нь тулгуурлаад цаашид авах арга хэмжээний асуудлуудыг хийх учраас би сонсьё гэж байна л даа. Бололцоотой. Би өөрөө бас Байнгын хорооны дарга хийж байсан хүний хувьд наадах чинь тухайн салбарын асуудлаар Байнгын хороо мэдээлэл сонсох үүрэгтэй байдаг байхгүй юу. Тэгэхээр энэ бололцоотой.

2 дахь асуудал дээр би бас зүгээр ШӨХТГ ч юм уу нөгөө энэ чинь манай Эдийн засгийн байнгын хорооны харьяа байгууллага учраас энэ дээр бас нэг мэдээлэл сонсчих нь зөв болов уу. Яагаад

гэвэл бид нарт хандаад, бас Эдийн засгийн байнгын хорооны гишүүн гэдгээр бид нарт хандаж байна. Өчигдөр бас Ерөнхий сайд хэлж байсан. Жижиг ресторан эрхлэгчдийн хувьд бас хүсэлт тавьж энэ асуудлаар хүртэл бид нартай уулзаж байсан гээд. Тэгэхээр энэ бол нэлээд асуудал болж байна л даа. Мааш олон жижиг, дунд бизнес эрхлэгчид хаалгаа барихад хүрээд байна. Тэгэхээр бид нар энэ энэ дээр мэдээлэл сонсьё гэж байгаа юм. Тэрнээс би шийдвэр гаргах тухай.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Оюунчимэг гишүүн ээ ингэе. Угаасаа энэ хуваарийн дагуу хуваарь дээр бол нэмж оруулъя гээд албан ёсоор санал хураахаа больчихъё. Зүгээр энэ дундуур байж байгаад л асуудалтай өдрөө бүгдээрээ энэ 2 чиглэлээрээ холбогдох байгууллагуудыг нь дуудаад мэдээлэл авчихъя тэгэх үү. Одоо үзэж байгаад бид нар ачаалал багатай Байнгын хорооныхоо хуралдааны өдөр зарлаад л өмнөх өдөр нь байгууллагуудаа дуудаад тэр дээр харин танд урьдчилаад мэдэгдчихье. Та өөрөө байж асуултуудаа тодорхой асууя. Энд оруулж болно. Яагаад гэвэл ачаалал гайгүй учраас. Тэгвэл эхнийх нь санал хураалгачихъя. 2-ыг нь бол бид нар явцаа тэр Шударга өрсөлдөөн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах агентлагаас нь дуудаж байгаад танд мэдээлэл өгүүлье.

**Баттөмөр** гишүүн асуулт асууя.

**Б.Баттөмөр:** Энэ 3 дугаар сар дуусахад үндсэндээ 9 хоног л үлдэж байна л даа. 10 хоног үлдэж байгаа юм. Тэгэхээр голдуу миний энд харснаар бол ажлын дэд хэсгүүд ажиллах юм байна. Тэгэхээр ажлын дэд хэсгүүд ажиллаад энд чухал хууль ялангуяа төлбөрийн чадваргүйдлийн тухай хууль. Тэгээд дээрээс нь энэ Аялал жуулчлалын тухай хууль гээд. Энэ хуулиуд дээрээ их сайн ажиллах, ажлын дэд хэсгээ ажиллуулах. Төмөр замын тээврийн тухай хууль гээд байгаа. Эд нар дээр дэд ажлын хэсгүүд

голдуу ажиллах юм байна. Дэд ажлын хэсгүүдээ ингээд ажиллуулъя гэж байна. Ер нь цаашидаа манай Эдийн засгийн байнгын хорооны одоо ажлын албаныхан байж байна. Сая тэр Оюунчимэг гишүүний хэлж байгаа томоохон зарим газруудын сонсголыг Эдийн засгийн байнгын хороон дээр тухайлбал 2050 гээд л нэг хөтөлбөр байна шүү дээ. Тэгээд 2050-ийн биелэлт нь ер нь ямар байгаа юм бэ. 2050-д чинь бол заачихсан байж байгаа шүү дээ. Үндсэндээ нэг хүнд ноогдох ДНБ 2008 онд 8200 доллар болно гээд. Тэгээд өнөөдөр 4500, 4600 л байгаа шүү дээ. Нөгөө Монгол төгрөгөөрөө өсөөд байдаг долларт шилжүүлэхээр байхгүй хани дандаа уналттай байж байна. Тэгээд энийг миний тооцоолсноор бол 2030 он хүртэл эдийн засгийн өсөлт бол 15% байж байж 1хүнд ноогдох ДНБ 8000 доллар болохоор байна. Тэгээд энэтэй холбогдуулаад ийм асуудал байж байгаа юм. Сая түрүүн яриад байгаа тэр бүтээмж гээд. Бүтээмжийн төв гээд нэг байгууллага байдаг юм гэсэн. Юу хийдэг юм мэдэхгүй. Одоо энэ статистикийн гаргаж байгаа бүтээмжийг яривал нэг тийм онолын юм гаргаад л томъёо хийчихсэн. Өөр ерөөсөө энэ дээр яг тэр бүтээмж 2.1 хувиар өссөн гэж байгаа байхгүй юу. 2.1% хувийн өсөлтийн цаад талын шалтгаанууд, задаргаа нь юу юм. Ажиллах хүч нь цөөрөөд, ДНБ жоохон өсөөд тэгээд ингээд бүтээмж нэмэгдэж харагдаад байна уу. Энэ сонсголууд өөрөөр хэлбэл мэдээллүүдийг дарга бас анхаарна уу. Энийг ер нь Эдийн засгийн байнгын хороон дээр 4, 5, 6 дугаар сарууд дээр гол гол газруудын мэдээллийг Эдийн засгийн байнгын хороон дээр сонсъё гэж.

Ингээд бидний баталсан Уул уурхайн биржийн хууль гайгүй сайн үйлчилж байна. Одоо үндсэндээ хэд хэдэн удаа дуудлага худалдаа хийчихлээ. Аман дээрээс нь 60 доллароор худалдаж байсан нүүрсийг өнөөдөр 182 доллар болгож 3 дахин өсгөж байгаа юм. Тэгээд л энэ дунд ажилладаг хүмүүс ийм их хэмжээний ашгийг л унагаж байсан юм харагдаж байна. Тэгэхээр энэ их зөв

зүйтэй боллоо. Яг иймэрхүү дорвитой тэр Баялгийн сангийн тухай хууль тэгээд цаашаа эдийн засгийг эрчимжүүлэх томоохон төслүүдийг эдийн засгийн эргэлтэд оруулах. Тухайлбал тэр Хармагтай гээд л байж байгаа. Асгат гээд л том том төслүүд байж байгаа шүү дээ. Энэ дээрээ бол Монгол улсын хөгжлийн гарцын чинь яг гол юу бол юу вэ гэхээр ер төрийн өмчтэй томоохон хувьцаат компаниудыг байгуулж, татвараа аваад үлдсэн ашгаасаа баялгийн сандаа хуримтлуулдаг Хятадын туршилага тийм байна шүү дээ. Тэгээд ийм ийм эдийн засгийн дорвитой өсөлт авчирдаг энэ хуулиуд, энэ сонсголууд, энэ мэдээллүүдийг бол цаашидын энэ 4, 5, 6 дугаар саруудад нэлээн сайн түлхүү оруулж өгөх ийм шаардлага байна гэсэн ийм зүйлийг би хэлэх гэж байгаа юм. Тэгээд энэ 3 дугаар сарын цаглавар болж байна. Санал нэг байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Ганибал гишүүн асуултаа асууя.

**Н.Ганибал:** Баярлалаа. Ер нь Эдийн засгийн байнгын хороон дээр хэлэлцэх асуудлууд их байна. Бид нар өмнөх чуулган дээр чуулганы цаг хугацаанд манай Эдийн засгийн байнгын хороо Ганхуяг гишүүнээр ахлуулсан маш том хуулийн өөрчлөлтийг бид хийсэн л дээ. Нөгөө Зөвшөөрлийн тухай асуудлыг цэгцлэх гэж. Тэгэхээр ер нь зүгээр хувийн хэвшлийнхэндээ эдийн засгийн чөлөөт зах зээлийн нийгмийг хамгаалах үндсэн үүрэг нь манай Байнгын хороон дээр бас байгаа байх. Тэгээд ер нь бол тухайн үед бол хуулийг хэлэлцэж байх явцад бол буцаагаад нөгөө төрийнхөнтэйгөө бид нар чинь тулаад байсан шүү дээ. Тэгээд төрийнхнийгөө бас тодорхой хэмжээнд тэр шалгуурыг давж Эдийн засгийн байнгын хороо маань бас хувийн хэвшлийнхэндээ бас ээлтэй хуулийг баталж чадсан. Тэгэхээр яг энэтэй адилхан хуулиудыг бид нар бас ер нь энэ зах зээлээ хамгаалсан, хувийн хэвшлийнхнийгээ дэмжсэн, төрөөс энэ зах зээлийнхээ зарчмыг хамгаалсан энэ



хуулиуд дээр бид нар эргээд ажиллах ёстой гэдэг нь бол тодорхой байгаа.

Дээрээс нь энэ инфляцтай холбоотой асуудлууд маань ер нь яг бодит амьдрал дээр инфляц яг 10.2 энэ тэр гэдэг бол худлаа шүү. Зүгээр энгийн малчдын хэрэглээн дээр гарч байгаа өөрчлөлт 2 жилийн өмнө 1 хониор 3 шуудай будаа авдаг байсан байхгүй юу. Одоо бол 1 хониор 1 шуудай будаа арай чүү л авч байгаа. Энэ чинь өөрөө хэрэглээний ямар том өөрчлөлтүүд орж байгаа гэдгийг бол ингээд бодит амьдралаар харагдаад байгаа байхгүй юу. Магадгүй энэ 3 сар бид нарт өгсөн мэдээллээр инфляц нэг арай буурсан гээд байгаа шүү дээ. Энэ чинь Монголчууд бүгдээрээ цагаан сараар 1 сарынхаа хэрэглээний асуудлыг ингээд шийддэг. Тэрийгээ хэрэглэдэг. Цагаан сараар бэлдсэн. Шууд худалдан авалт руу хүнсний худалдан авалт руу орохгүй байгаа байхгүй юу. Та бүхэн хүнсний зах дээр байгаа хүмүүсээс очоод асуугаад үзээрэй. Борлуулалт маш муу байгаа. Энэ 4 сард эргээд өснө. Яагаад гэхээр нөөцөлсөн мах, будаа, гурил ингээд бүх юмнууд сарын хэрэглээнүүд нь дуусчихна. Тэгэхээр эргээд бодит амьдрал дээр бол инфляц өснө. Тэгээд мөнгөний бодлого дээр бид нар Монгол банк явуулж байгаа, хэрэгжүүлж байгаа бодлогууд, Засгийн газраас явж байгаа томоохон нэртэй мөнгө нийлүүлдэг, мөнгө хэвлэдэг энэ асуудлуудыг бас цэгцлэх тал дээр манай Эдийн засгийн байнгын хороо зайлшгүй оролцох ёстой. Энэ дээр бас анхааруулан хэлэх ёстой. Тэгээд бодлогыг нь зөв болгох тал дээр бас бид ажиллах ёстой юм. Тэгээд ер нь Засгийн газраас гаргаж байгаа том хэмжээний хүнсний хувьсгал ч гэнэ үү 1 их наяд, 10 их наяд, 5 их наяд гээд нэртэй том том энэ хөтөлбөрүүд Монгол Улсын эдийн засгийг дээрээс нь инфляцыг өсгөж байгаа гэдэг дээр бол бүгдээрээ мэднэ. Гэхдээ энэ анхааруулж хэлдэг асуудлыг нь бас зөв талд нь болгох тал дээр хэлж ярих ийм байгууллагагүй болчихлоо. Тэгэхээр энэ дээр Эдийн засгийн байнгын хороо маань энэ

асуудлуудыг өөр дээрээ татаж авч бас асуудалд нь зөвлөмж, дүгнэлтүүдээ гаргаж өгөх шаардлагатай байх шиг байна. Баярлалаа.

### **Ц.Цэрэнпунцаг:**

Ганибал гишүүндээ болон сая ерөнхийдөө саналаа хэлсэн Баттөмөр гишүүн та бүхэнд баярлалаа. Энэ хаврын чуулганы Эдийн засгийнхаа байнгын хороогоор хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж байгаа. Энэ 3 сардаа хэлэлцэх асуудлаа бид нар батлах гэж байгаа учраас ерөнхийдөө санаануудаа ярьж байгаад талархаж байна. Ер нь цаашдаа бас энэ Байнгын хороон дээрээ бид нар сайхан чөлөөтэй, задгай ярилцаад бас дараа дараа сар сардаа бид нар энэ цаглавраа батлахын өмнө энэ оруулах санаануудаа албан бусаар уулзаж саналыг чинь авъя гэж бодож байгаа. Тийм учраас удахгүй Байнгын хорооноос нэг хоол идэнгээ бүгдээрээ зохион байгуулъя. Та бүхэн идэвхтэй оролцоорой. Ер нь бол 4 сараас угаасаа Баттөмөр гишүүн түрүүн санааг нь хэллээ. Энэ өөрийнхөө Монгол банкн дээр, Санхүүгийн зохицуулах хороо дээр, Статистикийн газар эд нар бол угаасаа жилийнхээ тайланг өгөх юм. Тэгээд сонсоод бүгдээрээ сонсохынхоо өмнө илтгэл, тайлангуудыг нь эртхэн шиг авхуулаад, тэр тайланг сонссоны дараа очих юм уу, өмнө нь очих юм уу. Та бүхэн шийдээд бүгдээрээ энэ байгууллагуудаар явъя гэж байгаа юм. Газар дээрээ очъё, үзье. Ер нь бид нар юу юун дээр бас ажилламаар байгаа юм. Ямархуу бодлого гаргамаар байгаа юм гээд бид нар эдийн засгийнхаа бодлогыг бас эндээ голлож гишүүдийнхээ саналыг бас сайн сонсоод, хэлэлцэх асуудал дээр энийгээ бөөгнүүлж, оруулж ярилцаж та бүгдийн саналыг энд тусгаж явж байх нь зүйтэй юм. Тийм учраас 4 сарынх дээр та бүхэн идэвхтэй оролцоорой. Энэ 3 сарын сүүлчээр дараагийн 7 хоногийн дундуур бүгдээрээ зохион байгуулаад та бүхэн э сард хэлэлцэх асуудлуудад ямар асуудлууд оруулмаар байна. Оюунчимэг гишүүний тавиад байгаа шиг асуудлууд үнийн асуудал байна гэж байна. Тэр

жижиг дэлгүүрүүд маань энэ өрсөлдөөнд шахагдаад байна гэсэн асуудлууд байна гэж байна. Иймэрхүү асуудлуудаа бид нар яаж сонсох юм. Эд нарыг бид нар яаж нэгтгэж Байнгын хороон дээрээ мэдээллийг яаж авч байх юм гэдэг дээр бүгдээрээ нэгдсэн хоорондоо зөвшилцөж байгаад ингээд заримыг нь албан ёсоорбид нар энэ хуваарь дээрээ оруулъя. Заримыг нь албан бусаар хажуугаар нь энэ мэдээллүүдийг аваад явах ийм олон сувгуудаар ажиллая гэж бодож байна.

Ингээд асуудалдаа орж 3 сард хэлэлцэх асуудлынхаа цаглаврыг хэлэлцье.

Гишүүд асуулт асууж, санал хэлж дууссан учраас санал хураалтаа явуулж эхэлье.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 2023 оны 3 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Гишүүдийн 70% нь дэмжиж санал дэмжигдлээ. Ингээд санал хураалт явуулж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 2023 оны 3 дугаар сард Эдийн засгийн байнгын хороогоор хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцүүлж дууслаа.

15.16 цаг.

**“Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Ингээд тогтоолын төслийн талаарх төсөл санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг танилцуулна. Ажлын хэсгийг танилцуулъя. Ажлын

хэсэг орж ирээд суусан байна. Ажлын хэсгийг би танилцуулаадахъя. Ч.Хүрэлбаатар Эдийн засаг, хөгжлийн сайд, Б.Баасандорж ЗГХЭГ-ын дэд дарга, Б.Цэнгэл ТӨБЗГ-ын дарга, Ш.Мөнхцэрэн ЗГХЭГ-ын Салбарын удирдлага зохицуулалтын газрын дарга, Д.Нямдэлгэр ЗГХЭГ-ын Салбарын удирдлага зохицуулалтын газрын Засгийн газрын референт, Д.Ган-Эрдэнэ Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт хэрэгжүүлэх газрын хяналт шалгалтын багийн ахлагч, Н.Найданболд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын менежментийн багийн ахлах нягтлан бодогч, Д.Нарангэрэл ТӨБЗГ-ын Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга. Ажлын хэсгийг танилцууллаа.

Чинзориг гишүүн та танилцуулгаа хийх үү. Засгийн газрын сайд танилцуулна. Чинзориг гишүүнд танилцуулга хийнэ. Чинзориг гишүүний микрофоныг нээе.

**С.Чинзориг:** Байнгын хорооны дарга, гишүүд ээ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлд Улсын Их Хурал Төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх шийдвэр гаргах бүрэн эрхтэй гэж заасан. Төрийн өмчид байгаа илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгийг хэрэгцээ шаардлагатай байгаа орон нутагт шилжүүлж, хөрөнгийн зохицуулалт хийх, Төрийн хэмнэлтийн тухай Засгийн газар дахь хяналтын тухай хуулиудын хэрэгжилтийг хангах, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, хяналтыг сайжруулах зорилгоор төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Засгийн газар дахь хяналтын тухай хууль батлагдсанаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газар 21 аймаг, нийслэл дэх салбар нэгжийг татан буулгаж, чиг үүргийг нь холбогдох

төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага орон нутагт хяналт, шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага хэрэгжүүлэхээр болсонтой холбогдуулан шилжин ажиллах төрийн албан хаагчдын ашиглаж байгаа тавилга, эд хогшил, хөдлөх хөрөнгийг орон нутгийн өмчит байгууллагад шилжүүлэх шаардлага үүссэн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрх эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу төрийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллогыг улс ор орон даяар зохион байгуулж, дүгнэлт, зөвлөмж гарган ажилладаг бөгөөд уг тогтоолын дүнгийн дагуу төрийн өмчөөс аймаг, нийслэлийн өмчид шилжүүлэх эд хөрөнгийг болон төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд татан төвлөрүүлсэн суудлын автомашиныг орон нутгийн хэрэгцээнд шилжүүлэх асуудлыг тогтоолын төсөлд мөн тусгасан болно.

Тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Ц.Цэрэнпунцаг:** Чинзориг сайдад баярлалаа. Төсөлтэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Баттөмөр гишүүнээр тасаллаа. Ундром гишүүн асуултаа асууя.

**Ч.Ундром:** Энэ тогтоолын төслийн танилцуулга дээр Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1-д Улсын Их Хурал төрийн өмчийг орон нутгийн өмчид шилжүүлэх тухай шийдвэр гаргана гэж заасан байна. Тэгэхээр Улсын Их Хурал бол шийдвэр гаргах субъект нь. Энэ оруулж ирсэн төсөл нь бол уге шийдвэр нь гарчихсан юм шиг ийм байдалтай орж ирж байна. Тэгэхээр яг ямар зарчим баримталж аймгуудад энэ өмчүүдийг хуваарилсан юм бэ. Зарим аймагт нь маш олон зүйл байна. Зарим аймагт нь ганц хоёрхон

зүйл байна л даа. Энэ жагсаалтыг нь харахаар. Одоо жишээлэх юм бол манай Сэлэнгэ аймгийн хувьд зам харгуйтай холбогдоогүй зарим аймгийн сумдаас ч том тосгод байна. Хүн болгон төрийн үйлчилгээг ялангуяа эрүүл мэндийн үйлчилгээг бүгдээрээ авах эрхтэй. Гэтэл тэр эрүүл мэндийн үйлчилгээг тосгон гэдэг утгаараа багийн статустай, тэгээд сумын төвөөс 80 километрийн зайтай, замгүй тосгон байна л даа. Тэгээд түргэний машин байхгүй ч гэдэг юм уу ийм асуудал байдаг. Гэтэл та бүхний хуваарилсан төслийг харахаар зарим нэг аймгийн Соёлын газар ч гэдэг юм уу бас нэг өөр аймаг, сумдын эрүүл мэндийн салбарт нэн зайлигүй хэрэгтэй газар хуваарилчхаж болохоор байсан ийм зүйлүүд харагдаж байна л даа. Тэгэхээр яг ямар зарчим баримталж та бүхэн энэ аймгуудад хуваарилсан юм бэ. Яагаад зарим аймаг нь нэг хоёрхон машин ч юм уу хуваарилагдаад, зарим нь 10, 20 эд хөрөнгө, машин, тоног төхөөрөмж хуваарилагдсан байдаг юм бэ? Яг зарчмыг нь надаа хэлээд өгөөч гэж асуумаар байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 1 номер хариулъя. 2 номерын микрофоныг нээе. Цэнгэл дарга хариулъя

**Б.Цэнгэл:** Ундром гишүүний асуултад хариулъя. Бид өнөөдөр 7 асуудал оруулж ирж байгаа. Ерөнхийдөө багцлагдаад. Энэ болохоор үл хөдлөх хөрөнгө шилжүүлэх, усан хангамж, ариутгах татуургын барилга байгууламжийг шилжүүлэх, Дарханы станцын хөрөнгөөр хийгдсэн гэрэлтүүлгийг орон нутагт нь шилжүүлэх, мөн нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт хүүхэд, эмэгтэйчүүдийн чиглэлийн байрыг дүүргийнхэнд нь харьяаллын дагуу шилжүүлэх, хэмнэлтийн хуулийн дагуу эрүүл мэндийн байгууллагад машин шилжүүлэх. Мөн Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу төрийн өмчөөс орон нутгийн өмчит бас тодорхой тооны машиныг шилжүүлэх. 7 дахь асуудал нь

бол мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдсантай холбогдуулаад зарим хөдлөх эд хөрөнгийг бас орон нутагт шилжүүлэх гэсэн ийм асуудлуудыг бол өнөөдөр Их Хурлын тогтоол болгож оруулж ирж байгаа.

Ундрам гишүүний тавьж байгаа асуулт бол нэн ялангуяа хэмнэлтийн хуулийн дагуу төвлөрүүлсэн тээврийн хэрэгслүүдийг орон нутагт хуваарилах асуудалтай холбогдуулж тавигдаж байгаа асуулт гэж би ойлгож байгаа. Ер нь Засгийн газрын хурал дээр бол манай Эрүүл мэндийн сайд бас санал гаргасан. энэ дээр мэргэжлийн хяналтаас татан буугдаж байгаатай холбогдуулаад хураагдаж байгаа машинуудыг эрүүл мэндийн системийн байгууллагуудад түлхүү хуваарилж өгөөч гэдэг хүсэлт гарсан. Энэ хүсэлтийг нь Засгийн газар бол дэмжиж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэ гэсэн. Энэ дээр нэг ньуанс хэлэхдээ бол яг тухайн үед бол өвөлжилт хүндэрсэн ийм цаг үе байсан. Тийм учраас яг хэрэгцээтэй цаг үед нь энэ тээврийн хэрэгслүүдийг орон нутагт нь хүргэж өгөх ажил бол их чухал юм гэсэн. Үүний дагуу бол Их Хурлын бүрэн эрхийн шийдэх асуудлыг нь бол тогтоолын төслөөр нь явуулъя. Зүгээр яг ашиглалтын гэрээ байгуулаад машин тэргийг нь хэрэгцээтэй байгаа газар нь хүргэж өгөх ажлыг цаг алдалгүй хийж байх нь зүйтэй гэдэг ийм Засгийн газрын чиглэл өгсөн. Энэ чиглэлийн дагуу ТӨБЗГ холбогдох байгууллагуудтай хамтарч энэ ажлыг зохион байгуулсан. Нэмэлт мэдээллийг манай Нарангэрэл дарга буюу нэгдүгээр микрофоноос өгнө. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 2 номерыг нээе. Нарангэрэл дарга хариулъя. 1 номерын микрофоныг нээе.

**Д.Нарангэрэл:** Сэлэнгэ аймгийн тухайд МХГ-ын 4 салбар нэгж нь нийслэл, аймгийн өмчтэй байгаагийн 1 нь Сэлэнгэ аймаг байдаг. Нийслэлийн өмчид байгаа МХГ Баян-Өлгий, Сэлэнгэ, Төв

аймгийн мэргэжлийн хяналтын газрууд аймагтаа өмч нь байдаг учраас Их Хурлын тогтоолд Төв аймаг, Сэлэнгэ аймаг, Баян-Өлгий аймгийн хувьд МХГ-ын эзэмшилд байсан хөрөнгө нь Их Хурлын тогтоолд орж ирээгүй байгаа. Сэлэнгэ аймаг дээр бол 2 автомашиныг орон нутагт шилжүүлэхээр төсөл дээр тусгасан байгаа. Саяын даргын хэлснээр МХГ-аас орон нутагт хүргэж болох боломжтой 2 машин нэмэгдэхээр ажлын хэсэгт танилцуулахаар саналаа бэлтгэсэн байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ундрам гишүүн нэмж асуух уу. Ундрам гишүүн нэмэлт асуулт асууя.

**Ч.Ундрам:** Надад бол яг нөгөө зарчим ерөөсөө хэлсэнгүй л дээ. Яг ямар зарчмаар та хэд энийг хуваарилсан юм бэ. Тэгэхээр би яг зарчмыг нь л сонсчихъё гэж бодож байна.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 1 номер нэмж хариулъя.

**Д.Нарангэрэл:** Зарчмын тухайд гэвэл үзэл баримтлал дээр байгаа гол Их Хурлын тогтоолд оруулах болсон үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг эхний ээлжид аймгуудаас нь санал тавьсан. Төрийн байгууллагуудад шинэ байр ашиглалтад орсноор хуучин барилгыг авч хүүхэд хөгжлийн төв болгоё гэсэн ийм саналууд ирээд хариуцсан байгууллага нь дэмжээд явж байгаа хэд хэдэн үл хөдлөх хөрөнгүүд байгаа. Эзэмшигч, ашиглагч байгууллага нь Ус сувгийн байгууллагууд нь орон нутгийн өмчид байгаа шугам сүлжээний байгууламжууд байгаа. Эрхэм гишүүний асуусан асуулт нь автомашин дээр төвлөрч хэлсэн юм болов уу гэж ойлгоод автомашин дээр бол бид нар байгаа автомашинуудыг байгаа газарт нь өгөхийг зорьсон. Сэлэнгэ аймаг дээр МХГ-ын Сэлэнгэ аймаг дээр өгөхөөр жагсаалтад оруулж байгаа машин гэхэд Орхон аймгийн мэргэжлийн хяналтын машинуудыг Сэлэнгэ аймаг руу шилжүүлэхээр тавьсан байх жишээтэй.



Тэгэхээр ер нь бол яг нутаг дэвсгэрийнхээ харьяаллаар байгаа байгаа газарт нь.../минут дуусав/

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгээс гүйцээгээд хариулчих уу. Ажлын хэсгийн 1 дээр гүйцээгээд хариулчихъя.

**Д.Нарангэрэл:** Тэгэхээр байгаа байгаа нутаг дэвсгэрийн нэгжийн харьяаллаар аймгийн өмчид шилжиж байгаа нэгдүгээрт.

Хоёрдугаарт, ер нь бол автомашинуудыг тэргүүн ээлжид эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлж эгсэн. Мөн өвөлжилт хүндэрч байгаа Засаг даргын Тамгын газруудад шилжүүлж байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Ундрам гишүүн тодруулж асуух уу. Ундрам гишүүн тодруулж асууя. Хариулт хангалтгүй учраас тодруулж асуух 1 минут.

**Ч.Ундрам:** Энэ жишээлбэл Өмнөговь аймгийн Соёл урлагийн газар өвөлжилт хүндрээд Соёл урлагийн газарт нь машин өгөх нь өөр нэг сум, аймгийн Эрүүл мэндийн газар өгөхөөс илүү чухал юм уу. Яг ямар зарчмаар энэ сумдад хуваарилсан юм бэ гэдэг чинь ер нь бол жоохон тийм субъектив шинж чанартай, шударга бус, зарим нэг Засгийн газрын гишүүнээр ажиллаж байгаа хүмүүсийн тойрог руу нь чиглэсэн шинж маягтай харагдаж байна. Тэгэхээр Монгол Улсын 21 аймагт амьдарч байгаа ард иргэдийг та нар ингэж алагчилж үзэж болохгүй. Яг зарчмаа тохироод л тэрнийх нь дагуу ялангуяа энэ машинуудыг би хэлж байна. Шилжүүлэх ёстой гэж.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсэг нэг номерын микрофон дээр хариулъя.

**Д.Нарангэрэл:** Соёл урлагийн газарт болон Эрүүл мэндийн газар, Хөдөө аж ахуйн газар, Боловсролын газар энд нэр дурдсан байгууллага

ялангуяа Өмнөговийн Соёл урлагийн газарт автомашин шилжүүлээгүй. Энэ автомашин шилжиж байгаа тохиолдолд бид нар бүгд автомашиныг нэрээр нь, хэний дансанд бүртгэлтэйгээр нь хэнд очиж байгааг нь бүгдийг нь биччихсэн байгаа. Тэгэхээр Соёл урлагийн газарт бол автомашин шилжүүлээгүй. Төсөл дотор бол яг Тамгын газар нь Тамгын газарт, Эрүүл мэндийн газарт Эрүүл мэндийн газар гээд биччихсэн ийм машинууд нь Засгийн газраас чиглэл өгсний дагуу Эрүүл мэндийн газар болон ЗДТГ-т шилжүүлж байгаа машинууд байгаа.

Орон нутгийн өмчийн газар гэж зарим нэг аймагт бичсэн машинууд нь яг аль сумдаа хэрэгцээтэй байгааг өөрсдөө судалж байгаад өгье. Зарим нэг сумд нь өөрөө сумын Эрүүл мэндийн төв дээр машин авсан байна гэсэн ийм асуудал ярьсан учраас бид нар өмчийн газар гэж тавьсан байгаа. Өөрийнх нь албан хэрэгцээнд биш очоод тэндээ хэрэгцээтэй газар шилжүүлж гээд. Түүнээс бусад төсвийн байгууллагууд дээр бол дандаа ширээ, сандал улсын байцаагчийн хэрэглэж байсан хөрөнгүүд байгаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Баттөмөр гишүүн асуултаа асууя.

**Б.Баттөмөр:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8.1.4-д Улсын Их Хурал төрийн өмчийн талаар төрийн өмчийг орон нутагт шилжүүлэх тухай шийдвэр гаргах бүрэн эрхтэй гээд мундаг бүрэн эрхтэй л юм байна. Энэ 1996 онд л батлагдсан төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль одоо ингээд үндсэндээ бараг 25 жил болчихсон юм уу 26, 27 жил ч болж байгаа юм уу. 10 хэдэн удаа өөрчлөлт орсон. Үгүй ээ, энэ ширээ, сандал хуваарилах, шилжүүлэхийг энэ Их Хурал дээр ярих хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу. Энэ хуучин автомашин, ширээ, сандал, улсын байцаагч нарын хэрэглэж байсан хуучин тоног төхөөрөмж энэ тэр гээд. Бид нэг

л гүйдлээ олохгүй байгаад байгаа юм биш үү. Цэнгэл дарга аа Та юу гэж бодож байна. Сая Үндсэн хуульд өөрчлөлт оруулаад яам байгуулах, Засгийн газрын сайд томилохыг Ерөнхий сайдад өгчихсөн шүү дээ. Одоо манай ТӨБЗГ энийгээ шийдээд явчхаж болдоггүй юм уу. Бүр болдоггүй юм бол тэр Засгийн газрын тогтоол гарчхаж болдоггүй юм уу. Ийм юм л би асуух гэж байгаа юм нэгдүгээрт нь.

Яах вэ дээ энд Мэргэжлийн хяналт татан буугдсантай холбогдуулаад баахан ширээ, сандал хэдэн автомашин л явж байх шиг байна. Би бол ТӨБЗГ төрийн өмч бол энэ төрийн өмчийн компаниудынхаа засаглалыг сайжруулах, үр ашгийг нь дээшлүүлэх, зардал хэмнэх энэ чиглэлд илүү анхаарал тавьж Улсын Их Хурлаар энэ эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлд ийм хуульд ингэж өөрчлөлт оруулж өгөөч гэдэг ийм том асуудлуудаа тавивал Монгол Улсын Их Хурал энэ дээр одоо ажилламаар санагдаад байгаа юм л даа. Энийг энэ олон улсын туршлага гээд тавьсан юмнаас нь харахаар үндсэндээ Компанийн тухай хууль, Иргэний хууль, холбогдох хуулиудаараа л шийдчихдэг л юм байна л даа. Заавал энд орж ирээд л баахан хүмүүс хуралдаад л суугаад байх ийм шаардлагагүй гэж үзэж байна. Тийм учраас энэ дээр нэг хариулт өгөөч. Одоо нэгэнт ороод ирсэн учраас одоо энэ дээр тэгээд энийг нь хэлэлцээд явах нь зөв л байх л даа. Хариулт авъя.

**Ц.Цэрэнпунцаг:** Ажлын хэсгийн 2 номер дээр Цэнгэл дарга хариулъя.

**Б.Цэнгэл:** Баттөмөр гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Баттөмөр гишүүний хэлж байгаатай 100 хувь санал нэг байгаа. Тэр ч утгаараа бол Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 1996 онд батлагдсан энэ хуульд бол 30 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт орж байсан. Гэхдээ энэ нэмэлт, өөрчлөлт орохдоо бол бодлогын хэмжээний нэмэлт, өөрчлөлт гэхээсээ илүү бусад хуулийг дагасан

шинжтэй нэмэлт, өөрчлөлт орж байсан. Гэтэл нийгмийн харилцаа маань ингээд яваад өгчихсөн. Хууль маань энэнээсээ хоцроод байгаа асуудал бий. Тухайлбал өнөөдөр та яг ярьж байна. Энэ хөдлөх эд хөрөнгийг ингээд төрийн өмчөөс орон нутаг руу шилжүүлэх асуудлыг Их Хурлын бүрэн эрхэд авч хэлэлцээд байна. Ширээ, сандал яриад байна гэж байгаа. Бид энэтэй санал нэг байгаа. Тийм ч учраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Их Хуралд өргөн барьчихсан байж байгаа. Хэлэлцэх эсэх асуудал нь бол дэмжигдчихсэн байж байгаа. Энэ асуудал дээр энэ бүх саяын ярьж байгаа зүйлүүдийг бол Засгийн газрын түвшинд нь ярьдаг байя гэдэг зарим тохиолдолд шууд ТӨБЗГ эрх хэмжээгээ шилжүүлээд ингээд хийдэг байдлаар төсөлд бол тусгачихсан байж байгаа гишүүн ээ. Баярлалаа.

**Ц.Цэрэнпунцаг:** Та нэмж асуулт байна уу. Баттөмөр гишүүн асуултаа асууж дууслаа. Чинзориг гишүүн асуултаа асууя.

**С.Чинзориг:** Энэ жилийн төсөв дээр эрүүл мэндийн салбарт их засварын мөнгө, тоног төхөөрөмжийн зардал ерөөсөө тавиагүй юм байна лээ. Яагаад ингэсэн юм гээд Сангийн яамтай ярихаар өмнөх 2, 3 жил ковидын үе гээд хамаг байдаг хөрөнгөө эрүүл мэндийн салбарт өгч байсан гээд, энэ жил тэгээд их засварын хөрөнгө ч байхгүй, тоног төхөөрөмжийн зардал ч байхгүй. Тэгээд ийм нэг шалдан газар л байгаа юм л даа. Тэгээд ковидын үеийн тэр хөрөнгө оруулалт нь тэгээд тоног төхөөрөмж авсан юм бол байгаа л байх. Тэгээд одоо аймгууд бол эмнэлгийн тусламж үйлчилгээ хүргэхээр унаа хэрэгтэй байна. Ялангуяа баруун аймгууд эд нар цаг их хүнд байсан отор нүүдэл ихтэй түргэний машин гээд байгаа юм. Тэгээд надад өгөх юм байхгүй. Тэгээд энэ орон нутгийн өмчид хөрөнгө шилжүүлэх ийм асуудал засаг дээр ярихаар нь манайх хүнд байна, унаа их нэхэх юм мөнгө байхгүй, тоног



төхөөрөмжийн зардал байхгүй гэсэн ашгүй Ерөнхий сайд ойлгоод энэ орон нутгийн өмчид шилжүүлэх хөрөнгийг ер нь тоног төхөөрөмж, машиныг бол эхний ээлжид эрүүл мэндийн салбарт хуваарил гэсэн ийм тэмдэглэл гарсан. Тэгээд би аймгуудынхаа саналыг нь харгалзаж үзэж байгаад эхийг нь эцээж, тугалыг нь тураахгүй гээд аймгуудад 70 машин л хуваарилна гэсэн юм л даа. Гэхдээ энэ шинэ машин биш. Ялангуяа голдуу нөгөө МХГ ашиглагдаж байгаа машинууд тэгээд тэр орон нутгийнх нь мэргэжлийн хяналтад байсан машин тухайн аймагт нь үлдээх ийм зарчим баримталсан юм байгаа юм. Тэгээд би нэг хуваарь өгсөндөө Цэнгэл дарга аа. Яг тэр саналаар хийгдсэн үү. Та хэд маань тэндээ бас дур мэдээд бид мэдэх ёстой гээд өөрчлөөд хаячихсан юм уу. Би сая 1, 2 аймаг харлаа. Тэгээд би маргааш чуулган дээр ороход нь дахиж сайн тулгаж харъя даа. Тэр өгсөн бичигтэйгээ. Миний яамнаас өгсөн тэр санал нэлээн өөр байх шиг л байх юм. Та нар ярихаараа далимдуулаад Ерөнхий сайд эрүүл мэндийн салбарт өгөөрэй гэсэн гээд надаар далимдуулж ам хаачхаад тэгээд хуваарь хийхдээ өөрсдөө өөр хуваарь хийчихсэн юм биш биз дээ. Би тэгж хардаад байна. Хэрвээ тэгсэн бол Цэнгэл дарга минь 2-уулаа чуулган дээр баахан хэрүүл болно шүү. Тэгж далимдуулахгүй шүү та нар. Би жаахан сэжиглээд байна. Би харин хувиараа авчраагүй байна. Маргааш чуулганд орохоор чинь тэрийг яг тулгаж харна. Тэрнээс зөрсөн юм байх юм бол би энийг чинь дэмжихгүй шүү Цэнгэл ээ.

**Ц.Цэрэнпунцаг:** Ер нь сайдаа та нар Засгийн газрын хуралдаанаар энэ юмаа тэндээ ярьчихаж болдоггүй юм уу. Тэндээ ярьчихаад ороод ирдэг бол зүгээр. Тэгээд Цэнгэл дарга та хариулчих. Ер нь бол орон нутагт чинь заавал ингээд нэг яамнууд дундаа хуваагаад, хуваарилаад хатуу тавьчихаасаа илүү Засаг дарга нь нэг гайгүй машинтай бол түүнийгээ бараг хуваагаад хэрэглэхдэг юм биш үү. Тамгын газар дээр байгаа гайгүйгээ.

Ингэхдээ явдаг гээд л нөгөө дарга нар чинь тэгэх юм байна лээ. Тэгэхээр та бүхэн тэр дээр жоохон уян хатан байгаарай. Тэгэхээр мэдэхгүй тэр сум дээр байгаа юмыг та бол их сайн мэдэж байгаа даа. Ер нь зүгээр сум дээр нэг сайн машинтай бол хуваагаад л тэгээд эрүүл мэндийн төвийнхөн нь ч, Тамгын газар нь ч хуваагаад л хэрэглээд байх шиг харагддаг юм байна лээ. Цэнгэл дарга та хариул даа. Ажлын хэсгийн 2 номерын микрофоныг нээе.

**Б.Цэнгэл:** Чинзориг гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр бид шинэ машин биш дандаа хуучин ер нь бол ихэнх машинууд нь бол элэгдээд дуусчихсан ийм машинуудыг л хуваарилж байгаа. Ер нь эрүүл мэндийн салбарынхан бол машиныг их голж байгаа. Бараг л ч манай машин дундаас муу юм байна гэж үзэж байгаа. Бид байгаа юмаа л хувааж байгаа. Бид эхлээд бол судалгаан дээр үндэслээд хуваалт хийчихсэн байсан. Засаг дээр гарсан саналын дагуу эрүүл мэндийн салбарын юмыг бол би Чинзориг сайдтай ярьж байгаад сайдын саналыг бас харгалзаж үзэх нь зүйтэй гэж үзээд сайдад энэ асуудлыг танилцуулаад яам дээрээ ярьж байгаад бидэнд бол жагсаалт дээр жаахан өөрчлөлт оруулаад ирүүлсэн. Яг ганц 2 сум дээр бол өөрчлөгдсөн юм бол бий сайд аа. Тэрийг бол бүгд тайлбартай. Тухайлбал бид нар яг энийг хуваарилах тухай асуудал яригдангуут таны эрүүл мэндийн тэр сумд өг гэдэг юман дээр бол машинтай тухайлбал байж таарч байх байгаа байхгүй юу. Шинэ машин авчихсан байх жишээтэй. Тэгэнгүүт тэрийг нь тухайн тойрогтоо байгаа Их Хурлын гишүүдтэй нь бас бид нар холбоотой байдаг. Ер нь ингэчихвэл яасан юм гээд тухайн орон нутгийн удирдлагуудтай нь ярьж байгаад энэ чинь маш машинтай шүү дээ тэгвэл энэ дээр ингэж машин өгөх юм ямар хэрэгтэй юм. Манай тэр сум чинь ийм байгаа шүү дээ гэдэг бас амьдрал дээр тийм юм болсон. Яг тэр болсон юмыг нь яг деталь юмыг 1 номерын

микрофон дээр манай Нарангэрэл дарга нэмэлт тайлбар өгнө.

**Ц.Цэрэнпунцаг:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Ингээд төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Гишүүд ээ, санал хураалт явуулж эхэлье. Саналын томъёоллыг уншъя. “Төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Баттөмөр гишүүн таны санал. Ундрэм гишүүний санал эсрэг гарсан байна. Ундрэм гишүүн та санал гаргах уу? Ундрэм гишүүний микрофоныг нээе.

**Ч.Ундрэм:** Миний саналын төхөөрөмж ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахиж санал хурааж өгнө үү.

**Ц.Цэрэнпунцаг:** Ундрэм гишүүний гаргасан горимын саналаар саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ анхааралтай байгаарай. Гишүүдийн жэран хувь нь дэмжиж саяын санал хураалт хүчингүй боллоо. Ингээд саяын санал хураалт хүчингүй болсон учраас түрүүчийн санал хураалтыг дахин явуулъя. Санал хураалт гишүүд ээ анхааралтай байгаарай. Санал хураалт сая хүчингүй болгочоод дахиж санал хурааж байна. Гишүүдийн 70% нь дэмжиж санал дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

Тогтоолын төслийг төслийг хэлэлцсэн талаар Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрэм танилцуулна.

Тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг дууслаа. Эдийн засгийн байнгын хорооны өнөөдрийн хэлэлцэх

асуудал дуусаж хуралдаан үүгээр өндөрлөж байна. Ингээд гишүүддээ идэвхтэй оролцсонд баярлалаа. Мөн ажлын хэсгийнхэнд баярлалаа.

15.42 цаг.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ  
Э.СУВД-ЭРДЭНЭ